

**ЦӨМИЙН МАТЕРИАЛЫГ БИЕЧЛЭН ХАМГААЛАХ ТУХАЙ 1980 ОНЫ
КОНВЕНЦЫН 2005 ОНЫ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛГАА**

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Монгол Улсын Их Хурлын 2015 оны “Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” 60 дугаар тогтоолд Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орохыг Засгийн газарт даалгасан.

Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийн талаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон. Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар конвенцын нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн дэмжсэн.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Гадаад харилцааны яам, Цөмийн энергийн комисс, Олон Улсын Атомын Энергийн Агентлаг (ОУАЭА)-тай хамтран “Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгаа, цөмийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны олон улсын эрх зүйн хэрэгсэл” сэдэвт өндөр түвшний зөвлөгөөн “Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгаа, цөмийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны холбогдолтой олон улсын конвенц, протоколд нэгдэн орохыг дэмжих нь” сэдэвт үндэсний хэлэлцүүлгийг 2023 оны 06 дугаар сарын 27-29-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсан.

Зөвлөгөөн, хэлэлцүүлгээр ОУАЭА-ийн цөмийн аюулгүй ажиллагаа (safety), цөмийн аюулгүй байдал (security), цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгаа (safeguards)-ны асуудлаар мэргэшсэн мэргэжилтэн, хуульчид Монгол Улсын төрийн байгууллага, судалгаа шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоод болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүдэд Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны нэгдсэн конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколын талаар үнэн зөв, бодит мэдээлэл, нэгдэн орох ач холбогдол, үр нөлөөний талаар нэгдмэл ойлголтыг өгсөн.

Дээрх арга хэмжээнүүдэд ОУАЭА-ийн Хууль, эрх зүйн газар, Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааны газар, Цөмийн аюулгүй байдлын хэлтэс, Цөмийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын газар, Цацрагийн үүсгүүр, тээвэрлэлт, хаягдлын аюулгүй ажиллагааны хэлтэс, Цөмийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын газар, Монгол Улсын Их хурлын гишүүд төлөөлөл, Засгийн газрын гишүүдийн төлөөлөл, УИХ-ын Тамгын газар, ҮАБЗ-ийн Стратегийн хэлтэс, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Гадаад харилцааны яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Батлан хамгаалах яам, Эрчим хүчний яам, Эрүүл мэндийн яам, Эдийн засаг хөгжлийн яам, Терроризмтой тэмцэх зөвлөл, Цөмийн шинжилгээний нэгдсэн институтийн бүрэн эрхт төлөөлөгч, Шинжлэх ухааны Академич, Зэвсэгт хүчний жанжин штаб, “Цэнхэр сүлд” ТББ, “Монголын цацрагийн хамгаалалтын нийгэмлэг”

ТББ, “Эвийн хүч эх нутгийн төлөө” ТББ, “Их бага баян шарга” ТББ, “Гамшгийн эсрэг үндэсний төв” ТББ, “Босоо Хөх Монгол” ТББ зэрэг 65 байгууллагын 150 төлөөлөгч оролцсон болно.

Түүнчлэн, 2004 онд НҮБ-ын Аюулгүй Зөвлөлийн 15 гишүүн 1540 дугаар тогтоолыг санал нэгтгэйгээр баталсан. Уг тогтоолыг НҮБ-ын гишүүн бүх улс орон биелүүлэх үүрэг хүлээдэг. Монгол Улс НҮБ-ын бүрэн эрхт гишүүнийхээ хувьд үндэсний хяналтыг Аюулгүйн Зөвлөлийн 1540 тоот тогтоолын дагуу сайжруулахад тусалцаа дэмжлэг үзүүлэх нааштай үндэс суурь бий болгож энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх үүрэг амлалт хүлээдэг.

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 2004 оны 1540 дугаар тогтоол нь үй олноор хөнөөх аюултай цөмийн, химийн, биологийн зэвсэг, тэдгээрийг тээгч хэрэгслийг түгээн дэлгэрүүлэхээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг төрийн бус (зэвсэгт бүлэглэл) этгээд боловсруулах, үйлдвэрлэх, олж эзэмших, тээвэрлэх, ашиглахыг хориглосон арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг бүтээхэд ашиглаж болох бараа бүтээгдэхүүн, эд зүйлсэд үндэсний хэмжээнд чанд хяналт тавихыг гишүүн орнуудад чиглэл болгодог.

Цөмийн аюулгүй байдлыг олон улсын эрх зүйн нэг ч баримт бичигт иж бүрэн, цогц байдлаар авч үздэггүй ба Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц болон түүний нэмэлт нь цөмийн материал ба цөмийн байгууламжийн биечлэн хамгаалалтын чиглэлээрх олон улсын эрх зүйн хувьд заавал дагаж мөрдөх цорын ганц баримт бичиг юм.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны 2005 оны нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орох хэрэгцээ, шаардлагын талаарх урьдчилан тандан судалгааг хийж гүйцэтгэлээ.

ХОЁР. АСУУДАЛД ХИЙСЭН ДҮН ШИЛЖИЛГЭЭ

2.1. Асуудлын мөн чанар, хамрах хүрээ

Конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал анх 1999 онд сөхөгдсөн бөгөөд 2001 онд АНУ-ын Нью-Йорк хотноо болсон террорист халдлагын дараа нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал улам эрчимжсэн. Энэхүү террорист халдлагад цөмийн материал ашиглаагүй боловч ийм төрлийн аюул заналаас урьдчилан сэргийлэх, улс орон бүр өөрийн цөмийн материал, цөмийн байгууламжийг биечлэн хамгаалах дэглэмийг бэхжүүлэх зорилгоор 2005 онд Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцод нэгдэн орсон улс орнууд Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотноо хуралдсан. Энэхүү бага хуралд 89 улсын төлөөлөгч оролцож, тухайн конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэр гаргасан.

Олон Улсын Атомын Энергийн Агентлаг нь энхийн зорилгоор ашиглаж буй цөмийн байгууламж, цөмийн материалыг үр дүнтэй биечлэн хамгаалах дэглэмийг дэлхий дахинд бий болгож хэвшүүлэх, цөмийн материал болон байгууламжийн эсрэг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, оролцогч улсуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд энэхүү Нэмэлтэд нэгдэн орохыг гишүүн орнуудад уриалсан.

2.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд

№	Эрх, ашиг сонирол хөндөгдөж буй этгээд	Эрх, ашиг сониролд нөлөөлөх хэлбэр
1	Оролцогч улс /Монгол Улс/	Нутаг дэвсгэрт биечлэн хамгаалалтын дэглэмийг бий болгох, хэрэгжүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Олон Улсын Атомын Энергийн Агентлаг болон бусад оролцогч улсуудтай мэдээлэл солилцох, харилцан тусламж үзүүлэх зэрэг болно.
2	Оролцогч улсын эрх бүхий байгууллагууд	Биечлэн хамгаалалтын төрөл бүрийн горимыг хэрэгжүүлэхтэй холбоотой үүрэг хариуцлагыг нарын тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд тухайн байгууламж болон материалын биечлэн хамгаалалтыг хангах үндсэн үүрэг хариуцлагыг хүлээдэг нөхцөлийг бий болгох; Биечлэн хамгаалалтын шаардлагыг холбогдох аюул заналын үнэлгээнд үндэслэн, шаталсан арга замаар тогтоох зэрэг болно.
3	Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага	Цөмийн материал, цөмийн байгууламжтай холбоотой үйл ажиллагаанд холбогдох эрх бүхий байгууллагын баталсан захиргааны хэм хэмжээний актын дагуу биечлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, цөмийн материал, байгууламжийн аюулгүй байдлыг хангах үүргийг хүлээх зэрэг болно.

2.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

Манай Улс одоогийн байдлаар их хэмжээний өндөр цацраг идэвхтэй цөмийн материал эсхүл цөмийн байгууламж байхгүй хэдий ч өөрийн орны өнөөгийн биечлэн хамгаалах шаардлагыг үндэслэн олон улсын стандартад нийцсэн биечлэн хамгаалах дэглэмийг бий болгох боломжтой. Ингэснээр 1986 онд нэгдэн орсон Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцоор хүлээсэн үүргээ улам бэхжүүлэх юм.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенц нь 1987 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Тус конвенцод 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 164 улс нэгдэн орж, 44 улс гарын үсэг зурсан байна. Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт нь 2016 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон ба 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар 136 улс нэгдэн орсон байна.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенц нь зөвхөн олон улсын тээвэрлэлтийн үеийн биечлэн хамгаалах арга хэмжээнд хамаарч байсан бол нэмэлт, өөрчлөлт нь цөмийн байгууламж, түүнчлэн дотоодын хэрэглээ, хадгалалт, тээвэрлэлтэд байгаа цөмийн материалд хамаарч байна. Мөн конвенцод хамаарах санаатай гэмт хэрэгт цөмийн материалыг хууль бусаар нэвтрүүлэх, цөмийн байгууламжид хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулах зэрэг асуудлууд нэмэгдэж, хорлон сүйтгэх ажиллагааны талаарх мэдээлэл солилцох, туслалцаа үзүүлэх өргөтгөсөн хамтын ажиллагааны зохицуулалтууд нэмэгдсэн.

Цөмийн технологийн хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэж буй өнөө үед Монгол Улс цөмийн материал, байгууламжийн аюулгүй байдлыг хангах чухал элемент болох биечлэн хамгаалалтын арга хэрэгслийг олон улсын түвшинд хангах, Монгол Улсын нутаг дэвсгэрт буй цөмийн материалын хэрэглээ, хадгалалт, тээвэрлэлтийг олон улсын түвшинд хангаж, биечлэн хамгаалалтыг дэглэмийг бий болгох нь шаардлага үүсэж байна.

Түүнчлэн, Цөмийн энергийн комиссын 2023 оны 07 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Цөмийн аюулгүй байдлыг хангах замын зураглалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний 1 дугаарт (**Ач холбогдол: Өндөр**) Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын нэмэлт (A/CPPNM)-д 2024 онд нэгдэн орно гэсэн байдлаар тусгасан байна.

Мөн НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1540 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах “Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 1. Үндэсний хууль тогтоомж бүлгийн 1.1. Олон Улсын гэрээнд нэгдэж орох хэсгийн А-д Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийн тухай протоколд нэгдэн орох ажлыг 2025 он гэхэд биелсэн байхлаар тусгасан байна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

Ерөнхий зорилго: Цөмийн байгууламж, цөмийн материалын хэрэглээ, хадгалалт, тээвэрлэлтийн үеийн биечлэн хамгаалалтыг хангах, биечлэн хамгаалалтын дэглэмийг бий болгох эрх зүйн орчныг олон улсын түвшинд хүргэх, хорлон сүйтгэх ажиллагааны үед өргөжүүлсэн хамтын ажиллагаа, дэмжлэг, мэдээлэл солилцох тогтолцоог бий болгох, Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн загварын дагуу тус агентлагын холбогдох мэргэжилтнүүд болон Монгол Улсын аюулгүй байдлыг хангах эрх бүхий байгууллагуудын төлөөллүүдтэй хамтран 2023 оны 11 дүгээр сард боловсруулж, ЦЭК-ын 2023 оны 07 дугаар тогтоолоор батласан Монгол Улсын Цөмийн аюулгүй байдлыг хангах замын зураглалыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний арга хэмжээний биелэлтийг хангах, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1540 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах “Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний биелэлтийг хангах;

Тодорхой зорилго: Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орох.

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу хоёрдугаар хэсэгт заасан зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
-----------------	------------------------------	------------------------------------	---------------

1	Тэг хувилбар (шинээр зохицуулалт хийхээс татгалзах)	Өнөөгийн тулгамдаж буй асуудлууд хэвээр үргэлжлэх тул зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч сөрөг үр дагавар нэмэгдэнэ.	Үр дүнд хүрэхгүй
2	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Нийтэд чиглэсэн ухуулга, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах, сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтийн цахим сүлжээ ашиглах, гарын авлага, мэдээллийн хуудас гаргах зэрэг нь цөмийн материал, цөмийн байгууламжийн биечлэн хамгаалалтыг сайжруулах зорилгыг хангахгүй.	Тодорхой хэмжээнд зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар үргэлжилнэ.	Үр дүнд хүрэхгүй
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Одоо тулгамдаж буй асуудлууд нь татвар хураамжийн бодлого, зэргээр тодорхой хязгаарлалт тогтоох зэргээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хамаарахгүй.	Тодорхой хэмжээнд зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэлжилнэ.	Үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Одоо тулгамдаж буй асуудлуудыг төрөөс шууд мөнгөн хэлбэрийн санхүүжилт үзүүлэх замаар шийдвэрлэхэд тохиромжгүй тул тус хувилбар зорилгод хүрч чадахгүй байна.	Төрөөс зардал гарах бөгөөд асуудлыг бүрэн шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэлжилнэ.	Үр дүнд хүрэхгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр гүйцэтгүүлэн асуудлыг шийдвэрлүүлэх боломжгүй байна.	Төрөөс зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэлжилнэ.	Үр дүнд хүрэхгүй
6	Захиргааны шийдвэр гаргах	Цөмийн материалын биечлэн хамгаалалтыг сайжруулахад тодорхой боломж бүрдэх боловч үр дүнд цогцоор ахиц гаргаж чадахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүн гарна.

7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Цөмийн материал, цөмийн байгууламжийг биечлэн хамгаалах, ОУАЭА болон бусад оролцогч улс орнуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох тогтолцоог цогцоор шийдэх боломжтой бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Тодорхой зардал гарах боловч цөмийн материал, байгууламжийг биечлэн хамгаалах дэглэмийг цогцоор бий болгож, олон улсын түвшинд хүргэх боломжтой.	Үр дүн эерэг байна.
---	--------------------------------------	---	--	---------------------

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

5.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх нөлөө:	Үр	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх				
		1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	-	-	Хамааралгүй
		1.1.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	-	Үгүй	
		1.1.3. Тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	-	-	Хамааралгүй
	1.2. Оролцоог хангах				
		1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцоо боломжийг бүрдүүлсэн эсэх	-	-	Хамааралгүй
		1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	-	
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага				
		1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	-	Цөмийн материал, цөмийн байгууламжид зөрчил, хорлон сүйтгэх ажиллагаа явагдахаас сэргийлнэ.
		1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	-	НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1540 дугаар тогтоолоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд

				хувь нэмэр оруулна.
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	-	Нэмэлтэд нэгдэн орсноор цөмийн материал, байгууламжийг хууль бусаар ашигласан, гэмтэл учруулсан зэрэгт хүлээлгэх хариуцлагыг улам бэхжүүлнэ.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	-	
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	-	Үгүй	
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	-	
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	-	-	Хамааралгүй
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	-	-	Хамааралгүй
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	-	-	Хамааралгүй
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	-	Эрх агуулагч Конвенцын дагуу зарим үүрэг хүлээнэ
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	-	-	Хамааралгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	-	-	Хамааралгүй

5.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	-	Цөмийн материал, цөмийн байгууламжийн биечлэн хамгаалалтын дэглэмийн болон хил дамнан хийгдэх шилжилт
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн	Тийм	-	

	засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)			хөдөлгөөнд найдвартай байдлыг болгоно. бий
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	-	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	-	Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	-	Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	-	Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	-	Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл ийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	-	Хэрэглэгч байгууллагуудад цемийн материал, цемийн байгууламжийн дотоодын хэрэглээ, хадгалалт, тээвэрлэлтийн үед биечлэн хамгаалалтыг хангах арга хэрэгсэлд зардал үүснэ.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	-	Үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	-	Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	-	Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	-	Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус	-	Үгүй	

	баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх			
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	-	Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	-	Үгүй	
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	-	Үгүй	
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	-	Үгүй	
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	-	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	-	Цөмийн материалын дотоодын хэрэглээ, хадгалалт, тээвэрлэлтийн үеийн биечлэн хамгаалалтад хамаарах ажлын байр бий болно.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	-	Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	-	Үгүй	

10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	-	НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1540 дугаар тогтоолоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд хувь нэмэр оруулна.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	-	Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	-	НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1540 дугаар тогтоолоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд хувь нэмэр оруулна.

5.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	-	Цөмийн материалын дотоодын хэрэглээ, хадгалалт, тээвэрлэлтийн үеийн биечлэн хамгаалалтад хамаарах ажлын байр бий болно.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	-	Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	-	Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	-	Биечлэн хамгаалалтын дэглэмийг бий болгосноор аюулгүй байдлыг өндөр түвшинд хангана.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	-	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	-	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	-	

3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	-	Үгүй	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	-	Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	-	Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	-	Биечлэн хамгаалалтын дэглэмийг бий болгох, олон улсын байгууллага болон оролцогч улсуудтай харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	-	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	-	Үгүй	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	-	Үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	

	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	-	Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	-	Биечлэн хамгаалалтын дэглэмийг бий болгосноор аюулгүй байдлыг өндөр түвшинд хангана. Болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	-	Биечлэн хамгаалалтын систем нь гэмт хэрэг илрүүлэхэд зэрэгээр нөлөөлнө.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	-	Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	-	Үгүй	

5.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	-	Үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	-	Үгүй	
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	-	Үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	-	Үгүй	

3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	-	Үгүй
	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	-	Үгүй
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	-	Үгүй
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	-	Үгүй
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	-	Үгүй
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	-	Үгүй
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	-	Үгүй
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	-	Үгүй
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	-	Үгүй
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	-	Үгүй
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	-	Үгүй
7. Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	-	Үгүй
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	-	Үгүй

5.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцсэн байх бөгөөд бусад хууль тогтоомжтой уялдсан байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН АЖЛЫН АЛБА

2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр